

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал .....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийсэн хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	18
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22

### Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ФИЛАРМОНИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.БАТТУЛГА  
ТАНАА

2020.02.20 № 06/533  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын филармонийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын филармонийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын филармонийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Улсын филарманийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Баттулга танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно. Үүнд: Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого, түүний зарцуулалтыг төсөвт тусгах, төсвийн зардлыг бүлэг хооронд шилжүүлэн тайлагнасан зөрчлийг дахин давтахгүй төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж дотоод хяналтыг сайжруулах.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын филарманийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын филарманийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 10 дугаар сарын 04-нөөс 2020 оны 02 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Бэст фортуна аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын филарманийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Бэст фортуна аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 015 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Улсын филарманийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Ард түмний урлан ургуулах их авьяас билгээр бүтсэн олон зууны хөгжмийн хөгжлийн уламжлалыг өрнө дахины соёл иргэншлийн гол ололт болсон “сонгомол” хөгжмийн дэвшил, орчин үеийн урсгал чиглэлтэй хослуулан хөгжүүлж бүх нийтийн хөгжмийн боловсролыг дээшлүүлэх”-д оршино.

Улсын филарманийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

Байгууллагын үйл ажиллагаа нь соёл урлагийн тоглолт, соёл урлагийг нийтэд сурталчлан таниулах түгээн дэлгэрүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албан хаагчдын тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоож баталсан Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоол,
- Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам баталсан Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол,
- Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам баталсан Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоол,
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам баталсан Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаал

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын филармони нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Улсын филарманийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улсын филарманийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,772,354.7 мянган төгрөгөөс тооцон 17,723.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,256,381.4 мянган төгрөгөөс 1 хувиар материаллаг байдлын түвшинг 22,563.8 мянган төгрөгөөр тооцсон болно.

## 2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын филарманийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 213,968.5 мянган төгрөгөөр буюу 59.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгө, Засгийн газрын хувь оролцоо дансуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	5,683.7	24,874.4	19,190.7
Бараа материал	104,505.2	102,478.3	-2,026.9
Үндсэн хөрөнгө	249,530.6	446,335.3	196,804.7
Биет бус хөрөнгө	709.1	24.7	-684.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>359,719.5</b>	<b>573,688.0</b>	<b>213,968.5</b>
Өр төлбөр	45.1	0	-45.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	359,674.4	573,688.0	214,013.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>359,719.5</b>	<b>573,688.0</b>	<b>213,968.5</b>

Авлага дансны өмнөх оны үлдэгдэл 5,683.7 мянган төгрөг бүрэн төлөгдөж тайлант онд 24,874.4 мянган төгрөгийн авлага шинээр үүссэн нь 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн тоглолтын орлого “Гэр медиа” ХХК буюу ticket.mn-ээс оны дараа төлөгдөн орж ирсэнтэй холбоотой ба сөрөг үр дагаваргүй болно.

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхнээс 2,026.9 мянган төгрөгөөр буурсан нь уран бүтээлчдийн хувцас, хөгжмийн нот, прощур худалдан авсан боловч үндсэн хөрөнгийн шинжтэй 33,250.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны ашиглалтгүй бараа материал байхгүй, хэвийн хэмжээнээс илүү нөөц үүсээгүй байна. Дээрх чухал хэрэгцээт, дутагдалтай материалыг худалдан авсан нь үлдэгдэлд сөрөг нөлөө үүсгээгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 295,065.2 мянган төгрөгөөр өссөн нь 250,000.0 мянган төгрөгөөр Баянмонгол чуулгын хөгжим шинэчлэгдсэн, ТӨБЗГ-аас зөвшөөрөл авсны дагуу дутагдалтай байсан хөгжим, тоног төхөөрөмж, тавилга худалдан авсан, бараа материалын данснаас хөрөнгө шилжүүлэн бүртгэсэнтэй тус тус холбоотой байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн авсан 249,675.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 9,524.5 мянган төгрөгийн хөрөнгөөр буурсан байна. Биет бус хөрөнгө хасагдуулгаар 684.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 45.1 мянган төгрөгийг тайлант онд төлж барагдуулан жилийн эцэст богино болон урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 573,688.0 мянган төгрөг болж 214,013.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 1,497.3 мянган төгрөгийн бичилт нь акталсан хөрөнгүүдийн дахин үнэлгээний зөрүүгийн алдаатай бичилттэй холбоотой байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын филармони тайлант онд нэмэлт санхүүжилтээр 148,655.9 мянган төгрөг, үүний 140,655.9 мянган төгрөг нь үндсэн үйл ажиллагааны орлогоор, 8,000.0 мянган төгрөг нь дээд шатны төсвийн захирагчийн санхүүжилтээр тус тус бүрдүүлсэн ба энэхүү орлогууд төлөвлөгдөөгүй байна.

Нийт орлого 148.655.9 мянган төгрөгөөр давсан нь өөрийн үйл ажиллагааны болон дээд шатны орлого төлөвлөгдөөгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх соёл урлагийн хөтөлбөрт зориулан 2,019,615.5 мянган төгрөгийн урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагджээ.



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын филармони нь тайлант хугацаанд эд хогшил худалдан авахад 38,281.1 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 57,840.0 мянга, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын зөрүүд 52,534.8 мянга буюу нийт 148,655.9 мянган төгрөгийн зардлыг өөрийн үйл ажиллагааны орлого, дээд шатны төсвийн захирагчийн хуваарилсан орлогоос тус тус санхүүжүүлсэн байна

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй харьцуулан үзэхэд 148,172.6 мянган төгрөгөөр хэтэрсэн мэт тайлагнагдсан боловч төлөвлөгдөөгүй орлогын эх үүсвэрээр санхүүжүүлсэн зардлуудтай холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй ба Сангийн яамнаас Баянмонгол чуулгын 50 жилийн ойд зориулж 249,675.6 мянган төгрөгийн хөгжмийн зэмсэг үнэ төлбөргүй бэлтгэсэн байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламж, гадаад төсөл хөтөлбөрөөс санхүүжилт аваагүй бөгөөд дээд шатны төсвийн захирагчаас 8,000.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 140,655.9 мянга буюу нийт 148,655.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Улсын филармони нь нийт 2,167,788.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 490.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 7 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 35,813.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс завсрын аудитын явцад иж бүрдэлгүй баримтаар гүйлгээ хийсэн 6,778.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 29,035.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Улсын филарманийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад үзэж амжаагүй асуудал байхгүй бөгөөд Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.4.3 “үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах” гэсэн заалтын дагуу байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого, зарцуулалтыг төсөвт тусгах асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзэж байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Улсын филармони нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны дансны нэгдсэн shilendans.gov.mn цахим хуудсанд 2019 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл бусад мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

### **2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 17,450.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх хариуг 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 064 албан тоотоор ирүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан болно.

2019 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 6,778.0 мянган төгрөгийн баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийгдсэн зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 0181 албан тоотоор ирүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Улсын филарманийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй материаллаг алдаа зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

#### **“Зөрчилгүй дүгнэлт”**

Улсын филарманийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурьдав.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

*Авто машины спидометрийн заалтгүйгээр явсан километрээр 2,800.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг тооцож, тооцоо бодсон нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна*

##### **1.2. Эрсдэл:**

*Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, хэтрүүлэн зарцуулах,*

##### **1.3. Өгсөн зөвлөмж:**

*Шатахуун зарцуулалтын нормыг мөрдөх, хэмжих хэрэгслэлээр гүйцэтгэлийг тооцох, дотоод хяналтыг сайжруулах*

##### **1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

*Зөрчлийг хүлээн зөвшөөрч завсрын аудитын зөвлөмжийн дагуу хэмжих хэрэгслийг авч суурилуулсан, зөрчлийг дахин давтахгүй*

## **1. Зардлын тушаал шийдвэрийн холбоотой асуудал**

### 2.1.Илрүүлэлт:

Албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгох тухай 2019 оны Б/063, Б/064 тоот тушаалын захирамжлах хэсэгт 25,735.9 мянган төгрөг олгох тухай дурьдаагүй нь Төрийн албан хэргийн хөтлөлтийн үндсэн зааврын заалттай нийцэхгүй байна.

### 2.2.Эрсдэл:

Үр дүнгийн урамшуулал илүү, дутуу олгогдох

### 2.3.Өгсөн зөвлөмж:

Тушаалыг төрийн албан хэргийн хөтлөлтийн үндсэн зааврын зааврын дагуу боловсруулан, хянаж, баталгаажуулж байх

### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **2. Төсвийн зарцуулалтын тайлагналтай холбоотой асуудал**

### 3.1.Илрүүлэлт:

Ахмад ажилтанд олгосон 500.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд бүлэг хооронд шилжүүлэн тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

### 3.2.Эрсдэл:

Төсвийн зардал хэтрэх, төсвийн гүйцэтгэл буруу тайлагнагдах

### 3.3.Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж байх

### 3.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч хойшид зөрчлийг давтахгүй ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **3. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого, түүний зарцуулалтыг төсөвт тусгах асуудал**

### 4.1. Илрүүлэлт

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг 2019 оны төсөвт тусгаагүй орхигдуулсан.

### 4.2. Эрсдэл

Жил бүр давтагддаг үндсэн үйл ажиллагааны орлогыг төсөвт тусгаагүйгээс орлого, зардлын гүйцэтгэлийг төсөвтэй харьцуулах боломжгүй болох, зориулалтын бусаар зарцуулах эрсдэл үүсэх

#### 4.3. Өгсөн зөвлөмж

*Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3.4.3 дугаар заалтыг мөрдөж ажиллах*

#### 4.4. Байгууллагаас өгсөн хариу *Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>110,188,893.00</u></b>	<b><u>127,352,658.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,683,700.00	24,874,400.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,683,500.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	200.00	24,874,400.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	104,505,193.00	102,478,258.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	52,263,169.00	64,036,169.00
35110	Тусгай зориулалттай материал	52,263,169.00	64,036,169.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	990,000.00	1,240,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	51,252,024.00	37,202,089.00
35470	Бусад хангамжийн материал	51,252,024.00	37,202,089.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>249,530,638.10</u></b>	<b><u>446,335,338.69</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	249,530,638.10	446,335,338.69
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	248,821,582.34	446,310,616.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	81,800,000.00	81,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,207,999.92	-73,287,999.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,001,649,426.67	1,278,143,473.67
39206	Хуримтлагдсан элэгдэл	-779,790,910.92	-864,005,709.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,030,800.16	90,077,400.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	-75,059,733.69	-71,216,548.43
39214	Бусад үндсэн хөрөнгө	57,832,435.72	57,832,435.72
39215	Хуримтлагдсан элэгдэл	-51,432,435.68	-53,032,435.64
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	709,055.76	24,722.36
39301	Програм хангамж	3,668,000.00	3,668,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,958,944.24	-3,643,277.64
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>359,719,531.10</u></b>	<b><u>573,687,996.69</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>45,098.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	45,098.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	45,098.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	45,098.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>359,674,433.10</u></b>	<b><u>573,687,996.69</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	359,674,433.10	573,687,996.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	390,738,376.57	390,738,376.57
51101	Өмч: - төрийн	390,738,376.57	390,738,376.57
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-115,886,499.28	99,624,355.11
51210	Өмнөх үеийн үр дүн	-115,886,499.28	-114,389,208.48
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	214,013,563.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	84,822,555.81	83,325,265.01
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>359,719,531.10</u></b>	<b><u>573,687,996.69</u></b>

#### 4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,745,809,177.55</b>	<b>2,470,394,989.09</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>111,546,400.00</b>	<b>282,925,580.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	111,546,400.00	282,925,580.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	111,546,400.00	282,925,580.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	111,497,400.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	49,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	282,925,580.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,634,262,777.55</b>	<b>2,187,469,409.09</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,612,501,400.00	2,019,615,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,532,638,900.00	2,019,615,500.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	79,862,500.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,761,377.55	167,853,909.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	8,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,761,377.55	159,853,909.09
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,778,038,180.93</b>	<b>2,256,381,425.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,778,038,180.93</b>	<b>2,256,381,425.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,723,633,248.25	2,153,049,915.41
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,281,543,310.00	1,566,410,611.00
210101	Үндсэн цалин	1,281,543,310.00	1,566,410,611.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	151,737,715.87	195,220,826.00
210201	Тэтгэврийн даатгал	103,924,733.00	135,307,888.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,941,988.00	15,900,987.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,298,076.87	12,547,988.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,245,638.00	2,717,868.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,327,280.00	28,746,095.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,260,400.00	41,260,400.00
210304	Байрны түрээс	41,260,400.00	41,260,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,088,672.00	24,489,774.00
210401	Бичиг хэрэг	4,104,898.00	3,974,490.00
210402	Тээвэр, шатахуун	4,737,600.00	4,737,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,201,500.00	5,250,000.00
210404	Ном, хэвлэл	83,200.00	203,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,961,474.00	10,324,484.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	649,100.00	24,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	649,100.00	24,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	17,446,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	527,400.00

Улсын филарманийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	00.00	16,919,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,500,000.00	4,992,000.00
210702	Дотоод албан томилолт	8,500,000.00	4,992,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	88,918,624.00	204,944,735.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	86,987,294.00	201,371,419.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	281,430.00	337,716.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,900.00	220,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	396,000.00	352,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	96,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	129,935,426.38	98,260,469.41
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	129,935,426.38	98,260,469.41
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	54,404,932.68	103,331,510.09
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,373,928.00	102,840,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,317,328.00	43,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,056,600.00	59,340,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	20,031,004.68	490,610.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,031,004.68	490,610.09
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-32,229,003.38</b>	<b>214,013,563.59</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-32,229,003.38</b>	<b>214,013,563.59</b>



### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,675,307,360.55</b>	<b>2,168,278,709.09</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>117,211,200.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	117,211,200.00	00.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	117,162,200.00	00.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	114,497,200.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,665,000.00	00.00
120009	Бусад орлого	49,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,558,096,160.55</b>	<b>2,168,278,709.09</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,532,638,900.00	2,019,615,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,532,638,900.00	2,019,615,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	21,761,377.55	148,663,209.09
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	8,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,761,377.55	140,663,209.09
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,695,883.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,695,883.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,666,602,960.55</b>	<b>2,140,839,119.09</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,666,602,960.55</b>	<b>2,140,839,119.09</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,612,198,027.87</b>	<b>2,038,007,609.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,285,239,193.00	1,482,262,674.00
210101	Үндсэн цалин	1,099,144,693.00	1,222,931,174.00
210102	Нэмэгдэл	72,694,500.00	144,939,400.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	113,400,000.00	114,392,100.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	151,692,617.87	185,293,700.00
210201	Тэтгэврийн даатгал	102,530,400.00	185,293,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,089,915.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,708,610.87	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,875,836.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,487,856.00	00.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,260,400.00	41,260,400.00
210304	Байрны түрээс	41,260,400.00	41,260,400.00

Улсын филарманийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,705,800.00	19,705,800.00
210401	Бичиг хэрэг	3,911,000.00	3,911,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,737,600.00	4,737,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,240,000.00	5,250,000.00
210404	Ном, хэвлэл	203,200.00	203,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,614,000.00	5,604,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,970,000.00	1,969,740.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,970,000.00	1,969,740.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	21,181,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,530,050.00
210602	Тавилга	00.00	100,500.00
210604	Урсгал засвар	00.00	18,551,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,000,000.00	4,992,000.00
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	4,992,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	104,665,017.00	281,341,745.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	102,715,117.00	277,662,429.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	271,300.00	337,716.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,900.00	220,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	32,700.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	425,000.00	458,700.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	96,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,665,000.00	00.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,665,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,404,932.68</b>	<b>102,831,510.09</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,373,928.00	102,340,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,317,328.00	43,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,056,600.00	58,840,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	20,031,004.68	490,610.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,031,004.68	490,610.09
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>8,704,400.00</b>	<b>27,439,590.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,704,400.00</b>	<b>27,439,590.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,704,400.00</b>	<b>27,439,590.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	8,704,400.00	27,439,590.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,704,400.00	27,439,590.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-8,704,400.00</b>	<b>-27,439,590.00</b>

#### 4.4 Аудит хийсэн хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	390,738,376.57	84,822,555.81	-89,340,995.90	386,219,936.48
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>390,738,376.57</b>	<b>84,822,555.81</b>	<b>-89,340,995.90</b>	<b>386,219,936.48</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-32,229,003.38	-32,229,003.38
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>390,738,376.57</b>	<b>84,822,555.81</b>	<b>-115,886,499.28</b>	<b>359,674,433.10</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,497,290.80	1,497,290.80
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>390,738,376.57</b>	<b>84,822,555.81</b>	<b>-114,389,208.48</b>	<b>361,171,723.90</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,497,290.80	00.00	-1,497,290.80
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	214,013,563.59	214,013,563.59
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>390,738,376.57</b>	<b>83,325,265.01</b>	<b>99,624,355.11</b>	<b>573,687,996.69</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан  
/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,019,615,500.00	2,019,132,209.00	483,291.00	99.98
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,019,615,500.00	2,019,132,209.00	483,291.00	99.98
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,975,115,500.00	1,974,632,209.00	483,291.00	99.98
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,482,348,900.00	1,482,262,674.00	86,226.00	99.99
210101	Үндсэн цалин	1,223,017,400.00	1,222,931,174.00	86,226.00	99.99
210102	Нэмэгдэл	144,939,400.00	144,939,400.00	00.00	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	114,392,100.00	114,392,100.00	00.00	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	185,293,700.00	185,293,700.00	00.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	125,999,600.00	185,293,700.00	(59,294,100.00)	147.06
210202	Тэтгэмжийн даатгал	14,823,500.00	00.00	14,823,500.00	00.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,858,900.00	00.00	11,858,900.00	00.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,964,800.00	00.00	2,964,800.00	00.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,646,900.00	00.00	29,646,900.00	00.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,260,400.00	41,260,400.00	00.00	100.00
210304	Байрны түрээс	41,260,400.00	41,260,400.00	00.00	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,705,800.00	19,705,800.00	00.00	100.00
210401	Бичиг хэрэг	3,911,000.00	3,911,000.00	00.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	4,737,600.00	4,737,600.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,250,000.00	5,250,000.00	00.00	100.00
210404	Ном, хэвлэл	203,200.00	203,200.00	00.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,604,000.00	5,604,000.00	00.00	100.00
2105	<b>Нормативт зардал</b>	1,970,000.00	1,969,740.00	260.00	99.99
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,970,000.00	1,969,740.00	260.00	99.99
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	5,000,000.00	4,992,000.00	8,000.00	99.84
210702	Дотоод албан томилолт	5,000,000.00	4,992,000.00	8,000.00	99.84
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	239,536,700.00	239,147,895.00	388,805.00	99.84

Улсын филарманийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	хураамж				
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	235,502,400.00	235,468,579.00	33,821.00	99.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	00.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	474,000.00	337,716.00	136,284.00	71.25
210804	Тээврийн хэрэгслийн татвар	425,600.00	220,900.00	204,700.00	51.90
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	80,000.00	66,000.00	14,000.00	82.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	458,700.00	458,700.00	00.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	96,000.00	96,000.00	00.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44,500,000.00</b>	<b>44,500,000.00</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>44,500,000.00</b>	<b>44,500,000.00</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,500,000.00	43,500,000.00	00.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,019,615,500.00</b>	<b>2,019,132,209.00</b>	<b>483,291.00</b>	<b>99.98</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,019,615,500.00</b>	<b>2,019,132,209.00</b>	<b>483,291.00</b>	<b>99.98</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,019,615,500.00	2,019,132,209.00	483,291.00	99.98
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>150</b>	<b>150</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	1	1	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	130	130	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	19	19	00.00	100.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>150</b>	<b>150</b>	<b>00.00</b>	<b>100.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	00.00	00.00	00.00	00.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	00.00	00.00	00.00	00.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	00.00	00.00	00.00	00.00
650010	Гэрээт ажилтан	00.00	00.00	00.00	00.00

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	00.00	148,655,890.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	00.00	148,655,890.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	00.00	90,814,990.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	38,281,140.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	10,150,540.00
210602	Тавилга	00.00	9,216,600.00
210604	Урсгал засвар	00.00	18,914,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	52,533,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	52,533,850.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	57,840,900.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	57,840,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	57,840,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	00.00	148,655,890.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	150	150
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	130	130
620003	Үйлчлэх ажилтан	19	19
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>150</b>	<b>150</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	00.00	00.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	00.00	00.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	00.00	00.00
650010	Гэрээт ажилтан	00.00	00.00

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Улсын филарманийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2019/12/31			САГ-2020/145/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Улсын филармони		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Спидометрийн заалтгүйгээр зөвхөн явсан километрээр шатахуун зарцуулсан	2,800.0	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодох бодогч	С.Баттулга Д.Бэхбат
2	2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Б/063, Б/064 тоот тушаалуудаар 168 хүнд олгосон шагналын дүнг тушаалд дурьдаагүй	25,735.9	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодох бодогч	С.Баттулга Д.Бэхбат
3	Төсвийн харилцахаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд бүлэг хооронд шилжүүлэн зарцуулж тайлагнасан	500.0	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодох бодогч	С.Баттулга Д.Бэхбат
4	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны жил бүр давтагддаг орлогыг төлөвлөөгүй	0	Зөвлөмж өгөх	Дарга, Ахлах нягтлан бодох бодогч	С.Баттулга Д.Бэхбат

